



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/155/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2021он

Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: ganulzii.t@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ш.Нарантуяа

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Гэрэлт хөхийн тэнцвэр  
Аудит” ХХК

Утас: 9611-2118 Цахим хаяг: Gerelt.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

## Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Аудитын тайлан .....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.9. Аудитын илрүүлэлт .....	17
Аудитын зөвлөмж: .....	<u>17</u>
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Менежментийн захидал .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<u>15</u>



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.28 № 1-6/141

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ДЭЛГЭРЭХ СУМЫН ЭРҮҮЛ  
ТӨВИЙН ДАРГА Э.ЧАНЦАЛДУЛАМ  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэрэх сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлгэрэх сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,219,714.49</b>	<b>61,407,191.48</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	926,236.00	3,626,049.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	926,236.00	3,626,049.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,293,478.49	57,781,142.48
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	13,212,559.68	21,706,594.98
35110	Тусгай зориулалттай материал	1,686,723.00	1,682,723.00
35130	Эм боох материал	11,525,836.68	20,023,871.98
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	31,080,918.81	36,074,547.50
35410	Бичиг хэргийн материал	3,864,240.00	3,415,590.00
35420	Аж ахуйн материал	16,996,579.31	21,850,869.00
35440	Түлш, шатах тослох материал	4,878,890.00	4,569,270.00
35460	Хүнсний материал	5,341,209.50	6,238,818.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>267,803,932.03</b>	<b>248,500,862.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	267,803,932.03	248,500,862.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	259,803,932.03	239,061,696.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	189,397,644.00	189,397,644.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,207,856.69)	(5,999,046.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,785,000.00	31,785,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,635,889.02)	(10,942,722.42)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60,661,628.00	63,211,428.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,763,952.08)	(45,120,589.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,141,489.00	12,891,489.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,901,557.37)	(7,697,880.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	99,672,469.00	99,672,469.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(77,345,042.81)	(88,136,095.08)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,000,000.00	9,439,166.72
39301	Програм хангамж	385,000.00	2,112,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(385,000.00)	(672,833.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,000,000.00	8,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>313,023,646.52</b>	<b>309,908,054.41</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>933,827.00</b>	<b>15,515.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	933,827.00	15,515.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	933,827.00	15,515.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	843,000.00	15,515.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>312,089,819.52</b>	<b>309,892,539.41</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	312,089,819.52	309,892,539.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	236,581,519.55	236,581,519.55
51101	Өмч: - төрийн	236,581,519.55	236,581,519.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(2,856,552.77)	(5,053,832.88)
51210	Өмнөх үеийн үр дүн	(54,648,413.61)	(2,856,552.77)
51220	Тайлант үеийн үр дүн	51,791,860.84	(2,197,280.11)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,364,852.74	78,364,852.74
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>313,023,646.52</b>	<b>309,908,054.41</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>352,744,490.00</b>	<b>351,627,644.83</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>340,881,290.00</b>	<b>9,067,420.83</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	43,090,000.00	9,067,420.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,090,000.00	9,067,420.83
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,090,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		1,727,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		7,340,420.83
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	18,592,390.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	18,592,390.00	-
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	279,198,900.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	279,198,900.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,863,200.00</b>	<b>342,560,224.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	284,923,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	284,923,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,100,800.00	16,440,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,100,800.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16,440,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,762,400.00	22,256,844.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,762,400.00	22,256,844.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	18,938,880.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	18,938,880.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>300,952,629.16</b>	<b>347,029,048.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>300,952,629.16</b>	<b>347,029,048.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	298,632,421.16	346,068,494.64
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	185,364,555.00	211,645,229.58
210101	Үндсэн цалин	140,500,000.00	144,263,229.96
210102	Нэмэгдэл	32,099,200.00	47,999,999.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,968,787.00	4,752,000.00
210104	Урамшуулал	10,796,568.00	14,630,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,106,802.00	27,553,938.00
210201	Тэтгэврийн даатгал	15,757,873.00	19,497,455.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,797,413.00	2,083,520.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,534,954.00	1,709,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,464.00	353,051.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,652,098.00	3,910,412.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,431,609.00	16,600,875.00
210301	Гэрэл, цахилгаан	1,340,609.00	1,811,875.00
210302	Түлш, халаалт	7,791,000.00	14,539,000.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,787,275.69	23,953,939.31
210401	Бичиг хэрэг	2,614,450.00	2,694,750.00
210402	Тээвэр, шатахуун	14,169,930.00	14,362,988.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	845,000.00	1,542,240.00

**Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	570,339.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,037,895.69	4,779,322.31
210408	Бараа материал акталсны зардал	-	4,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,678,435.60	19,300,023.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,578,380.00	13,805,313.65
210502	Хоол, хүнс	3,100,055.60	5,494,710.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,988,600.00	2,877,199.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	299,999.00
210604	Урсгал засвар	2,988,600.00	2,577,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,763,500.00	1,440,000.00
210702	Дотоод албан томилолт	1,763,500.00	1,440,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,904,574.00	14,366,721.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,548,364.00	13,908,321.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,200.00	33,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	10,000.00
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,607,069.87	28,330,569.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,693,500.00	4,000,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,913,569.87	24,329,869.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,320,208.00	960,553.42
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,320,208.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,320,208.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	200.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	960,353.42
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	960,353.42
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>51,791,860.84</b>	<b>4,598,596.77</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	6,795,876.88
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	6,443,331.58
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	-	352,545.30
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(6,795,876.88)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>51,791,860.84</b>	<b>(2,197,280.11)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан  
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>291,062,100.00</b>	<b>342,560,224.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,863,200.00</b>	<b>342,560,224.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	284,923,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	284,923,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,100,800.00	16,440,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16,440,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,762,400.00	22,256,844.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,762,400.00	22,256,844.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	18,938,880.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	18,938,880.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>300,690,090.00</b>	<b>339,260,424.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>300,690,090.00</b>	<b>339,260,424.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>298,369,882.00</b>	<b>338,299,870.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	185,365,355.00	216,181,999.58
210101	Үндсэн цалин	140,500,000.00	148,799,999.96
210102	Нэмэгдэл	32,100,000.00	47,999,999.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,968,787.00	4,752,000.00
210104	Урамшуулал	10,796,568.00	14,630,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,106,802.00	28,031,259.00
210201	Тэтгэврийн даатгал	15,795,227.00	19,974,776.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,797,413.00	2,083,520.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,497,600.00	1,709,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,464.00	353,051.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,652,098.00	3,910,412.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,906,609.00	20,418,075.00
210301	Гэрэл, цахилгаан	1,340,609.00	1,811,875.00
210302	Түлш, халаалт	7,266,000.00	18,404,800.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	201,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,537,881.00	18,362,059.00
210401	Бичиг хэрэг	2,482,500.00	1,543,300.00
210402	Тээвэр, шатахуун	15,594,730.00	10,836,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,799,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,779.00	1,182,215.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,999,872.00	2,999,924.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	31,469,961.00	28,014,584.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,475,665.00	20,767,700.00
210502	Хоол, хүнс	4,999,396.00	5,246,884.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,994,900.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,133,600.00	7,007,568.00

**Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,285,000.00	1,646,799.00
210602	Тавилга	-	222,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,848,600.00	2,638,569.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,763,500.00</b>	<b>1,440,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,763,500.00	1,440,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,613,274.00</b>	<b>12,971,426.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,257,064.00	12,677,026.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,200.00	33,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	10,000.00
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,472,900.00</b>	<b>5,872,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,472,900.00	5,872,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,320,208.00</b>	<b>960,553.42</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	200.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	960,353.42
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	960,353.42
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(9,627,990.00)</u></b>	<b><u>3,299,800.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,964,400.00</b>	<b>3,299,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,964,400.00</b>	<b>3,299,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,964,400.00</b>	<b>3,299,800.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	2,549,800.00
223001	Бусад хөрөнгө	-	750,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(8,964,400.00)</u></b>	<b><u>(3,299,800.00)</u></b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	236,581,519.55	78,364,852.74	(54,648,413.61)	260,297,958.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>236,581,519.55</b>	<b>78,364,852.74</b>	<b>(54,648,413.61)</b>	260,297,958.68
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	51,791,860.84	51,791,860.84
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>236,581,519.55</b>	<b>78,364,852.74</b>	<b>(2,856,552.77)</b>	312,089,819.52
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>236,581,519.55</b>	<b>78,364,852.74</b>	<b>(2,856,552.77)</b>	312,089,819.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>236,581,519.55</b>	<b>78,364,852.74</b>	<b>(2,856,552.77)</b>	312,089,819.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,197,280.11)	(2,197,280.11)
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>236,581,519.55</b>	<b>78,364,852.74</b>	<b>(5,053,832.88)</b>	309,892,539.41

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	328,681,500.00	325,159,070.58
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	328,681,500.00	325,159,070.58
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	328,681,500.00	325,159,070.58
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	216,182,000.00	216,181,999.58
210101	Үндсэн цалин	148,800,000.00	148,799,999.96
210102	Нэмэгдэл	48,000,000.00	47,999,999.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,752,000.00	4,752,000.00
210104	Урамшуулал	14,630,000.00	14,630,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,847,400.00	28,031,259.00
210201	Тэтгэврийн даатгал	20,299,800.00	19,974,776.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,136,800.00	2,083,520.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,709,500.00	1,709,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	427,700.00	353,051.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,273,600.00	3,910,412.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,968,000.00	20,418,075.00
210301	Гэрэл, цахилгаан	1,066,000.00	1,811,875.00
210302	Түлш, халаалт	21,782,600.00	18,404,800.00
210303	Цэвэр, бохир ус	119,400.00	201,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,736,900.00	17,718,659.00
210401	Бичиг хэрэг	1,040,300.00	1,040,300.00
210402	Тээвэр, шатахуун	10,696,600.00	10,696,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,799,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,182,215.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,999,924.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14,495,700.00	14,486,784.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,495,700.00	7,495,700.00
210502	Хоол, хүнс	5,000,000.00	4,991,084.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,550,000.00	8,507,368.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,200,000.00	4,196,599.00
210602	Тавилга	1,000,000.00	972,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,850,000.00	1,838,569.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,440,000.00	1,440,000.00
210702	Дотоод албан томилолт	1,440,000.00	1,440,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,588,600.00	12,502,026.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,230,400.00	12,207,626.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	160,000.00	160,000.00

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ТОГТООХ		
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,200.00	33,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	10,000.00
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,872,900.00</b>	<b>5,872,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,872,900.00	5,872,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>328,681,500.00</b>	<b>325,159,070.58</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>284,923,900.00</b>	<b>283,963,546.58</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	284,923,900.00	283,963,546.58
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>24,818,000.00</b>	<b>22,256,644.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	24,818,000.00	22,256,644.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>18,939,600.00</b>	<b>18,938,880.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,939,600.00	18,938,880.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>19.00</b>	<b>19.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>16,440,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>16,440,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	16,440,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	643,400.00
210401	Бичиг хэрэг	503,000.00
210402	Тээвэр, шатахуун	140,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,527,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,272,000.00
210502	Хоол, хүнс	255,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00
210604	Урсгал засвар	800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	469,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	469,400.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	16,440,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	16,440,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,440,600.00

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Э.Чанцалдулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, аудитор Ш.Нарантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн заслын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
- Эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх;
- Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ оношилгоо, шинжилгээ хийх
- Сумын хүн амын нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын оролцоог хангаж, орчны эрүүл мэндийн үзүүлэлтийг сайжруулах;

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/87 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажилласан байна.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д” Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”.(2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална” (2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолын 5-д “Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 347,029.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,941.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

### **3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос -3,115.59 мянган

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын дансанд материаллаг өөрчлөлт гарсан данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө			0.00
Авлага	926.23	3,626.04	2,699.81
Урьдчилгаа			
Бараа материал	44,293.47	57,781.14	13,488.00
Үндсэн хөрөнгө	267,803.93	248,500.86	-19,303.07
<b>Нийт хөрөнгө</b>	<b>313,023.64</b>	<b>309,908.05</b>	<b>-3,115.59</b>
Өр төлбөр		15.51	15.51
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	312,089.81	309,892.53	-2,197.28
Хуримтлагдсан үр дүн	-2,856.55	-5,053.83	2,197.28
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,364.85	78,364.85	0.00
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>313,023.64</b>	<b>309,908.05</b>	<b>-3,115.59</b>

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын тайлангийн үлдэгдэл 57,781.1 мянган төгрөг болж 13,487.6 мянган төгрөг болж өссөн нь эм боох материал 8,498.0 мянга, хүнсний материал 897.6 мянга, аж ахуйн материал 4,854.29 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,026.8 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 3,299.8 мянга, хандив тусламжаар 1,727.0 төгрөг программ худалдан авсан нь шалтгаалжээ. Бусад зардлын тооцоо болох 3,626.0 мөнгөний авлагатай ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 309,892.5 мянган төгрөг болж -2,197.2 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь тайлант оны элэгдлийн зардал болон үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

2020 оны мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого өмнөх оноос 51,498.1 мянган төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Нийт зардал өмнөх оноос 38,570.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 328,681.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хоёр хөтөлбөр, дөрвөн арга хэмжээг санхүүжүүлэхээр 328,681.5 мянган төгрөгийн төсөв аймгийн ИТХ хуралдаанаар баталж санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 284,923.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22,256,8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн гүйцэтгэлээрх санхүүжилт 18,938.8 мянган төгрөг авч, 342,560.2 мянган төгрөгийг зарцуулж 960.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

№	Зардлын бүлгийн код	Зардлын бүлгийн нэр	Үүнээс: 2020 он		
			Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү (+,-)
<b>Урсгал зардлын тооцоо</b>					
1	2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	216,182,000.0	216,181,999.6	0.4
2	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,847,400.0	28,031,259.0	816,141.0
3	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,968,000.0	20,418,075.0	2,549,925.0
4	2104	Хангамж, бараа материалын зардал	17,736,900.0	17,718,659.0	18,241.0
5	2105	Нормативт зардал	14,495,700.0	14,486,784.0	8,916.0
6	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,550,000.0	8,507,368.0	42,632.0
7	2107	Томилолт зочны зардал	1,440,000.0	1,440,000.0	
8	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	12,588,600.0	12,502,026.0	86,574.0
9	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,872,900.00	5,872,900.00	0
10	2131	Гадаад урсгал шилжүүлэг	0	0	0
11	2132	Бусад урсгал шилжүүлэг	0	0	0
<b>Урсгал зардлын дүн</b>			<b>328,681,500.00</b>	<b>325,159,070.58</b>	

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 643.4 мянга, нормативт зардалд 13,272.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 1,800.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 469.4 мянган төгрөгийг зарцуулжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 2020 оны 149 мэдээллийг бүрэн мэдээлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ил тодын самбарт нээлттэйгээр бүрэн байршуулсан байна.

Тус онд шилэн дансанд мэдээлэх 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитын илрүүлэлтээр алдаа зөрчил гараагүй болно.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад алдаа, зөрчил илрээгүй.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дэлхий дахинд дэгдэж буй Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагын эргэлтийн болон үндсэн хөрөнгөнд биет шалгалт хийгээгүй ба тухайн байгууллагын аудитад өгсөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас түүвэрлэн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч нөхөн сэргээж цаашид ашиглах шаардлагатай хөрөнгүүд байна.

Мөн УСНББОУС-ын дагуу тооцоолсон цалингаар цалингийн өглөг үүсгээгүй, цалингийн зардалд шууд бичилт хийгдсэн байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд өгөөгүй болно.